

ОНЗА-гийн Боловсролын зөвлөхийн ёс зүйн дүрэм

1. Үйлчлүүлэгч 1-т

Бид үйлчлүүлэгч бүрийн сонирхол, зорилгыг нэн тэргүүнд тавьж, боловсролын зөвлөгөөг хувь хүн бүрийн онцлогт тохируулан, хараат бус, урт хугацааны хөгжил дэвшил, сайн сайхан байдалд нь дэмжлэг болох байдлаар өгнө.

2. Ил тод байдал

Бид боломжит сургалтын хөтөлбөрүүд, төлбөрийн бүтэц, визний шаардлага болон амьдрах орчны нөхцөл байдлын талаар үнэн зөв, шинэлэг, тэнцвэртэй мэдээллийг өгнө. Бодит бус амлалтууд өгөхгүй.

3. Нууцлал

Бид үйлчлүүлэгч болон тэдний гэр бүлийн хувийн, боловсролын болон санхүүгийн нөхцөл байдлын мэдээллийг чандлан хадгалж, зөвхөн тухайн этгээдийн зөвшөөрлөөр холбогдох талуудад хуваалцана.

4. Хүндлэл

Бид үйлчлүүлэгчийг боловсрол, нийгмийн гарал үүсэл, ажил албан тушаал, үзэл бодол, итгэл үнэмшлээс үл хамааран тэгш, хүндэтгэлтэй хандана.

5. Мэргэжлийн байдал

Бид боловсролын системийн, хамтран ажилладаг сургуулиудын дүрэм журмыг цаг алдалгүй судалж, сахин мөрдөж, ашиг сонирхлын зөрчилгүй, мэргэжлийн өндөр түвшний үйлчилгээг үзүүлнэ.